



“Олон улсын уул уурхайн зөвлөх болон инженерчлэлийн үйлчилгээ”-г

уурхайн хөгжүүлэлтээс олборлолт хүртэлх бүх үе шатанд



Бидний тухай

DMT нь салбартаа тэргүүлэгч уул уурхайн зөвлөх болон инженерчлэлийн үйлчилгээ үзүүлэгч групп компани юм. Бид тив болгонд байрлах салбаруудаараа дамжуулан дэлхийн өнцөг булан бүрд үйлчлүүлэгчиддээ өөрсдийн үйлчилгээг санал болгодог. DMT нь 10000 гаруй ажиллагсадтай Германы томоохон групп компани болох TÜV Nord Group-ийн гол салбар компани бөгөөд групп компанийнхаа Уул уурхай, инженерчлэлийн үйлчилгээг хариуцаж ажилладаг. Манай уул уурхайн зөвлөх үйлчилгээний салбарууд Герман, Бахрейн, Канад, Энэтхэг, Индонез, Казахстан, Перу, Орос, ӨАБНУ, Турк болон Их Британи улсуудад байршдаг.



Хайгуул · Баялаг/Нөөцийн тооцоолол · Уурхайн загварчлал ·
(ХАБ ба Байгаль орчин) · ТЭЗҮ · Олборлолтын үеийн дэмжлэг ·
Магадлан шинжилгээ · Захиргааны тайлан · Үнэлгээ ·
Эзэмшигч болон зээлдэгчийн инженер

Үйлчилгээ

DMT компани нь уурхайн бүтээн байгуулалт болон олборлолтын бүхий л шатанд дэмжлэг үзүүлдэг. Бид дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд эрдсийн хайгуул, нөөцийн тооцоолол, төслийн үнэлгээ, инженерчлэлийн нарийвчилсан загварчлал, бүтээн байгуулалтын үеийн дэмжлэг, үйлдвэрийг ашиглалтад оруулалт буюу хүлээлгэж өгөх мөн уурхайн олборлолтын бүх үе шатуудад буюу оновчлол, уурхайн нөхөн сэргээлт болон эцсийн хаалт зэрэг багтдаг. Бид мөн хөрөнгө оруулагч, зээлдэгчдэд болон засгийн газар, хуулийн фирмүүд, даатгалын компаниудад хараат бус техникийн болон зөвлөх үйлчилгээг үзүүлдэг. Бидний мэргэжлийн чадвар, үйлчилгээ нь бүх төрлийн эрдсийн түүхий эд болон уурхайн ил ба далд бүх төрлийн олборлолтыг хамардаг.

Үүрэг

DMT нь хараат бус, мэргэжлийн, олон талт цогц зөвлөгөөг үзүүлдэг бөгөөд уул уурхайн бүх чиглэлд мэргэшсэн мэргэжилтнүүдийнхээ тусламжтайгаар үйлчлүүлэгчиддээ бүх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажилладаг. Бид голчлон Хайгуулын зөвлөх, гэрээлэгч эсвэл менежер, Итгэмжлэгдсэн этгээд (Competent/Qualified Person), Төслийн менежер, Консултант/техникийн зөвлөх, Гэрчлэгч эксперт, Техникийн аудитор болон Эзэмшигчийн эсвэл зээлдэгчийн Инженерийн үүргийг гүйцэтгэдэг.

Мэргэжилтнүүд

Бидний мэргэжлийн өндөр төвшний үйлчилгээ нь манай чадварлаг экспертүүд болон олон улсын уул уурхайн салбарт хуримтлуулсан арвин туршлага дээр суурилдаг. Манай олон салбарын мэргэжилтнүүдийн баг нь 700 гаруй өөрсдийн мэргэжилтнүүдээс гадна хамтран ажилладаг 300 гаруй хараат бус экспертүүдээс бүрддэг. Бидний бизнесийн үндсэн зарчим нь хэрэглэгчидтэйгээ ойр ажиллаж, эрч хүчээр дүүрэн, хүчирхэг, чадварлаг баг бий болгож үйлчлүүлэгчидтэйгээ урт хугацааны хамтын ажиллагааг тогтоохын тулд мэдлэг туршлагаа түгээхийг чухалчилдаг.

Үүрэг хариуцлага

Манай компани нь ажиллагсад, үйлчлүүлэгчдийнхээ болон бидний үйл ажиллагаанд хамаарах бүхий л хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй бөгөөд тав тухтай байдлыг нэн тэргүүнд чухалчилдаг. Бид төсөл хэрэгжиж буй улсынхаа ёс заншил, хууль журмыг дээдэлж, ажилдаа бүхий л талаас тухайлбал байгаль орчин, нийгэм болон бизнесийн хувьд мэргэжлийн өндөр төвшинд хариуцлагатай ажилладаг. Энэхүү хариуцлагаа компанийн маань ажилчин бүр цаг тутамд ухамсарлах замаар компани даяараа баримталдаг. Манай (DMT) чанарын систем ISO 9001:2008, ISO 14001:2004 стандарт-аар баталгаажсан бөгөөд бид бүх төсөлдөө энэхүү стандартыг мөрддөг.

Харилцагчид

Манай харилцагчдын тоонд нэр хүндтэй, олонд танигдсан төрөл бүрийн уул уурхайн компаниуд багтдаг. Тухайлбал, туслах хайгуулын/хөгжүүлэлтийн компани, банк болон зээлдэгч байгууллагууд, хувийн өмчийн хөрөнгө оруулагчид, засгийн газрууд, хуулийн фирмууд, даатгалын компаниуд болон тусламжийн агентлагууд хамаарна.



Геологи, Баялаг/ Нөөцийн Тооцоолол

DMT нь бүс нутгийн хайгуулын ажлын төлөвлөлтөөс хэрэгжүүлэлт хүртэлх геологийн өргөн хэмжээний үйлчилгээг санал болгодог бөгөөд жишээлбэл хайгуулын талбайг сонгох, өрөмдлөг болон дээжлэлтийн удирдлага мөн өгөгдөл боловсруулах зэрэг багтана.

Бид тогтмол эрдэс баялгийн, нөөцийн тооцоололд хяналт хийх болон бэлтгэх үйлчилгээг үзүүлдэг бөгөөд эрдэс баялгийн, нөөцийн тайланг олон улсын код стандартын дагуу бэлтгэх арвин туршлагатай.



Манай компани Итгэмжлэгдсэн этгээдийн зэрэглэлтэй ахлах зөвлөх мэргэжилтнүүдийг авч ажиллуулж бүх төрлийн уурхайн төрөл бүрийн эрдсийн түүхий эдийг олборлоход олон нийтэд нээлттэй эрдэс баялгийн, нөөцийн тооцоог хийлгэдэг. Манай геологичид болон уул уурхайн инженерүүд үйлдвэрийн төлөвлөлтийн стандарт програм хангамжууд дээр ажиллах чадвартай байдаг нь бидний гүйцэтгэсэн ажил үйлчлүүлэгчийн ашиглаж буй техник, технологиудтай нийцэх боломжийг олгодог. DMT нь мөн хайгуулын ажилд зориулсан орчин үеийн дэвшилтэт олон төрлийн төхөөрөмжүүдийг хөгжүүлж, үйлдвэрлэж, ашиглаж мөн борлуулж байна.

- Хайгуул
- Геологийн зураглал
- Агаарын ба гадаргуун Геофизик
- Өрөмдлөг ба Дээжлэлтийн удирдлага
- Өгөгдлийн баталгаажуулалт
- Чанарын баталгаа, Чанарын хяналт
- Геологийн загварчлал
- Баялгийн болон Нөөцийн тооцоолол
- JORC, CIM, SEC, PERC & SAMREC Тайлагнал
- Баялгийн, Нөөцийн хөндлөнгийн шалгалт

Хөрөнгө оруулагч / Зээлдэгчдэд тусламж

DMT нь банкууд, зээл олгогч, хөрөнгө оруулагчдад, хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргаж буй компаниудад мөн компанийн худалдан авалтад хараат бус техникийн тусламж болон зөвлөгөө өгч байсан олон жилийн туршлагатай.



Бид дараах үйлчилгээнүүдийг үзүүлэх арвин туршлагатай. Хөрөнгө босголтын төслүүдэд дэлхий дахинд байршиж буй манай мэргэжилтнүүд төсөл хэрэгжиж буй газарт дүгнэлт гаргахын зэрэгцээ бид Лондонд байрлах салбараараа дамжуулан санхүүгээ нэмэгдүүлэх тал дээр санхүү болон хуулийн байгууллагатай ойр ажилладаг. Банкуудтай хамтарч ажиллах үед бидний анхны даалгавар техникийн магадлан үнэлгээгээр эхэлж хараат бус зээлдэгчийн инженерийн үүргийг биелүүлэх болон уул уурхайн төслийн бүтээн байгуулалт мөн түүний зээлийн хугацаан дахь олборлолтын явцыг хянах байдлаар цааш үргэлжилдэг.

- Зээлдэгчдэд зориулсан хараат бус инженер
- Магадлан шинжилгээ
- IPO болон M&A тусламж
- Захиргааны тайлангуудад: CPR, MER, NI43-101 г.м
- Техникийн шалгалт, аудит
- Санхүүгийн загварчлал
- Үнэлгээ, SAMVAL, CIMVAL, VALMIN
- Худалдан авалт болон гэрээ
- Бүтээн байгуулалтын үеийн хяналт
- Экспертийн нотолгоо

ТЭЗҮ, нарийвчилсан инженерийн загварчлал болон хөгжүүлэлт



Манай уул уурхайн салбарын ахлах мэргэжилтнүүд танд уул уурхайн төслийн техник болон эдийн засгийн үнэлгээ, загварчлал хөгжүүлэлтийн үйлчилгээг өндөр чанарын гүйцэтгэлтэйгээр санал болгож байна. Бидний мэргэжлийн өндөр төвшний үйлчилгээ нь манай чадварлаг олон төрлийн мэргэшсэн экспертүүд болон олон улсын уул уурхайн үйлдвэрлэлд хуримтлуулсан арвин туршлага дээр суурилдаг.

Бидний чадавх төслийн хэмжээгээр хязгаарлагдаггүй. Бид массын түүхий эдийн уурхайгаас боомт хүртэлх цогц дэд бүтэцтэй төсөл дээр ажиллахдаа, ховор болон үнэт металлын жижиг уурхайн төслийг хэрэгжүүлдэгтэйгээ адилхан өндөр чанартай ажилладаг.

- Урьдчилсан эдийн засгийн үнэлгээнүүд
- Тойм судалгаа
- Урьдчилсан ТЭЗҮ
- ТЭЗҮ
- Зах зээлийн судалгаа, эдийн засаг
- Эрсдэлийн үнэлгээ & Эрсдэлийн удирдлага
- Уурхайн дэд бүтцийг оролцуулаад нарийвчилсан инженерийн зураг төсөл, Материал хангамж, Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны удирдлага
- Уурхайгаас боомт хүртэлх төлөвлөлт
- Оновчлолын судалгаа
- Худалдан авалт & Сургалт

Мэргэшсэн уурхайн инженерчлэл / ЭЗЭМШИГЧИЙН ИНЖЕНЕР

DMT нь Гүн далд уурхайтай холбоотой олон төрлийн инженерчлэлийн нарийн багаж төхөөрөмжүүд болон үйлчилгээг хөгжүүлсэн. DMT бол Эзэмшигчийн инженерийг санал болгодог цөөхөн уул уурхайн зөвлөх компаниудын нэг бөгөөд, ингэснээрээ бид үйлчлүүлэгчиддээ уурхайн төлөвлөлт, бүтээн байгуулалт, ашиглалтын бүх шатанд дэмжиж ажиллаж чаддаг.

Бид уул уурхайн үйлдвэрлэлийн салбарт урт хугацаанд ажилласан туршлага дээрээ үндэслэн гүн далд уурхайд зориулсан олон төрлийн инженерийн нарийн багаж төхөөрөмжүүдийг хөгжүүлж эзэмшсэн. Бид голчлон уурхайн оновчлол болон олборлолтын үеийн эрсдэлийг бууруулах зориулалттай орчин үеийн инженерийн шийдлийг санал болгодог.

Дэлхий дахинд олон төрлийн уурхайн бүтээн байгуулалт болон олборлолтын төслүүдэд оролцон хуримтлуулсан туршлага, мэдлэг дээрээ үндэслэн бид Эзэмшигчийн инженерийн үйлчилгээг санал болгодог. Энэхүү үйлчилгээний хүрээнд манай мэргэжилтнүүд төсөл хэрэгжүүлж буй газартаа урт болон дунд хугацаанд ажиллах бөгөөд ингэснээр Уул уурхайн төслийн зураг төсөл, бүтээн байгуулалт болон олборлолтын явцад хяналт тавих замаар уурхайн эзэмшигч болон төслийн хөгжүүлэгчдэд илүү сайн туслалцаа үзүүлэх боломжтой болдог. Хэрвээ үйлчлүүлэгч хүсвэл, бид (DMT) практикт суурилсан болон үйлдвэрлэлд шаардлагатай сургалтуудыг санал болгох боломжтой.

- Гүн босоо амны инженерчлэл
- Далд уурхайн бэхэлгээ
- Уурхайн хөгжүүлэлт ба олборлолтын оновчлол
- Далд уурхайн Backfill (буцаан дүүргэлт) системийн загварчлал болон барилгын ажил
- Уурхайн агааржуулалт & Хийн хяналт
- Усны урсцын загварчлал болон усны чанарын удирдлага
- Түүхий эдийн тээвэр ложистикийн системийн инженерчлэл
- Уурхайн хаалтын төлөвлөгөө & Нөхөн сэргээлт
- Эзэмшигчийн инженер





DMT Зөвлөх үйлчилгээний салбар оффисууд

Канада Улс –
Калгари & Ванкувер хотуудад

DMT Geosciences Ltd.
Утас: +1 403 264-9496
canada@dm-group.com

ХБНГУлс – Эссэн хот

Уул уурхайн зөвлөх
Утас: +49 201 172-1529
Уул уурхайн инженерчлэл
Утас: +49 201 172-1133
essen@dm-group.com

Энэтхэг улс – Колката хот

DMT Consulting (P) Limited
Утас: +91 33 2324-0096
india@dm-group.com

DMT GmbH & Co. KG

Am TÜV 1
45307 Essen, Germany

Утас +49 201 172-1466
Факс +49 201 172-1735

essen@dm-group.com
dm-group.com

Индонез Улс – Жакарта хот

PT DMT EEC Indonesia
Утас: +62 21 798-1987
indonesia@dm-group.com

Казахстан Улс – Алматы хот

Утас: +7 777 2990-610
kazakhstan@dm-group.com

Перу Улс – Лима хот

Утас: +49 201 172-1529
peru@dm-group.com

ӨАБНУлс – Йоханнесбург хот

DMT Kai Batla Pty Limited
Утас: +27 11 781-4548
johannesburg@dm-group.com

Турк Улс – Истанбул хот

DMT GmbH & Co. KG
Merkezi Almanya İSTANBUL
MERKEZ ŞUBESİ
Утас: +90 212 293 2980
turkey@dm-group.com

Их британи Улс, Ноттингхам
болон Лондон хотуудад

DMT Consulting Ltd.
Утас: +44 1623 397-100
uk@dm-group.com

Ойрх Дорнод –
Бахрейн & Абу Даби

DMT Middle East WLL
Утас: +973 1 78 77 391
middle-east@dm-group.com



DIN EN ISO 9001
DIN EN ISO 14001
DIN ISO 45001